



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/12/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: У.Батчимэг

Утас: 88094175

цахим хаяг: batchimegu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	6
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэл.....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Материаллаг байдал.....	9
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	9
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	9
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
4.5.1 Завсрын аудитын талаар.....
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ХААДС	Хөдөө аж ахуйг дэмжих сан



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.03.15 № 2/96

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ААТҮГ нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төлөөлөн удирдах зөвлөлөөр зорилт түвшин батлуулаагүй, Хөдөө аж ахуйг дэмжих санаас хөнгөлөлттэй үнээр ирж буй хөрөнгө, бараа материалд үнэ нэмэгдүүлэн худалдаалсан, байгууллагын харилцах данснаас хүүгүй зээл олгосон, төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, өөрөө өөрийгөө бие даан санхүүжүүлэх зарчмаар ажиллаагүй, санхүүгийн тайланг стандарт маягтаар үнэн зөв илэрхийлэн ирүүлээгүй, авлага, өглөг үүсгэн ажилласан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ААТҮГ-т Хөшөөт хөгжил сангаас ажилчдын цалин хөлсний зардлыг шийдвэрлэх зорилгоор 106.2 сая төгрөгийг орлогын эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг ТУЗ-аас нарийвчлан батлаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тухайн байгууллагын газар тариалангийн үйл ажиллагаа явуулж буй газар нь 2016 оны 04 дүгээр сарын А/29 дугаар захирамжаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр захирамж гарч тухайн захирамжийг 2018 оны 09 дүгээр сарын 21 ны өдрийн А/106 тоот захирамжаар хүчингүй болгосон байхад газрын гэрчилгээгээр ХААДС-с барьцаалбар үүсгэн 935.9 сая төгрөгийн үнэ бүхий усалгааны системийн тоног төхөөрөмжийг урьдчилгаа тэлбөргүй жилийн 6 хувийн хүүтэй гэрээ байгуулан авсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн хүлээх үүрэг, хариуцлага

Компанийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(Мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	56,621.4	39,139.8
1.1.2	Дансны авлага	47,300.0	25,663.4
1.1.4	Бусад авлага	1,404.7	4.7
1.1.6	Бараа материал	329.9	36,896.2
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	201.7	0.0
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	105,857.7	101,704.1
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0
1.2.1	Үндсэн хөрөнгө	238,772.7	1,163,956.4
1.2.2	Биет бус хөрөнгө	0.0	937.5
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	238,772.7	1,164,893.9
1.3	Нийт хөрөнгийн дүн	344,630.4	1,266,598.0
2.1.1.1	Дансны өглөг	237,799.5	325,930.5
2.1.1.2	Цалингийн өглөг	47.4	1,102.6
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	237,846.9	327,033.1
2.1.2.1	Урт хугацаат зээл	100,000.0	0.0
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	100,000.0	0.0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	337,846.9	327,033.1
2.3	Өмч	2,000.0	2,000.0
2.3.1	-төрийн	2,000.0	2,000.0
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,250.0	967,819.3
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,533.5	-30,254.4
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,783.5	939,564.9
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	344,630.4	1,266,598.0

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	87,286.8	195,568.2
2	Борлуулалтын өртөг	82,811.7	188,514.6
3	Нийт ашиг (алдагдал)	4,475.1	7,053.6
8	Бусад орлого	0.0	24,336.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	0.0	22,229.3
12	Бусад зардал	941.6	41,698.2
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,533.5	-32,537.9

20	Татварын дараахь ашиг (алдагдал)	3,533.5	-32,537.9
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,533.5	-32,537.9
24	Орлогын нийт дүн	3,533.5	-32,537.9

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	3,250.0	0.0	0.0	3,250.0
2	Залруулсан үлдэгдэл	3,250.0	0.0	0.0	3,250.0
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	3,533.5	3,533.5
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	3,250.0	0.0	3,533.5	6,783.5
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-1,250.0	0.0	-1,250.0	-2,500.0
2	Залруулсан үлдэгдэл	2,000.0	0.0	2,283.5	4,283.5
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	967,819.3	-32,537.9	935,281.4
8	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,000.0	967,819.3	-30,254.4	939,564.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	Мөнгөн орлогын дүн	87,286.8	329,962.2
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	87,286.8	195,568.2
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.0	134,394.0
1.2	Мөнгөн зарлагын дүн	84,194.8	347,443.8
1.2.1	Ажиллагчдад төлсөн	32,953.6	75,892.6
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,743.2	8,726.7
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,977.8	0.0
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,338.2	0.0
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,017.5	35,308.3
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	3,182.8	0.0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	40,981.7	227,516.2

1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,092.0	-17,481.6
2.2	Мөнгөн зарлагын дүн	13,171.6	0.0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,171.6	0.0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-13,171.6	0.0
3.1	Мөнгөн орлогын дүн	114,001.0	0.0
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	114,001.0	0.0
3.2	Мөнгөн зарлагын дүн	47,300.0	0.0
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	47,300.0	0.0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	66,701.0	0.0
4	Валютын ханшийн зөрүү	0.0	0.0
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	56,621.4	-17,481.6
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.0	56,621.4
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	56,621.4	39,139.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорацн нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, стратеги баримт бичиг тусгагдсан зарим төсөл, хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран санхүүжүүлэх, төр хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааны зохистой хэлбэрийг сонгох, Холдинг компани үйл ажиллагаа, аж ахуй нэгжийн удирдлага дээд байгууллагын толгой компани үйл ажиллагаа, Зах зээлийн болон социологийн судалгаатай холбогдох үйл ажиллагаа, Менежментийн зөвлөгөө өгөх хөрөнгө оруулах менежментийн үйл ажиллагаа, Хөрөнгө ашиглалт үр өгөөжийг нэмэгдүүлэх, Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн итгэмжлэн удирдах, Хөрөнгө оруулалтын зөвлөгөө үйлчилгээ үзүүлэхээр байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ААТҮГ статустай бүртгэгдсэн байна.

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорацн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн сан нь бэлэн 2 сая төгрөгөөс бүрдсэн байна.

3.2 Үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорацн ААТҮГ нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухайн хууль, Татварын тухай хууль, Аж, ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг мөрдөж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорацн ААТҮГ-ын үйл ажиллагаанд ТУЗ болон бусад байгууллагаас хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорацн ААТҮГ нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн бие даасан

орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна. 4-д “ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.” гэсэн заалттай нийцэж байна.

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорац ААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөл байгуулсан нь аймгийн ИТХ-ын 11 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 1.2 дах “орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт тавин ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөлд даалгасгай” гэсэн заалттай нийцсэн байна

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорац ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорац ААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тухайн тайланг Монгол улсын сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 361 тоот тушаалаар батлагдсаны дагуу залуулан хүлээн авлаа.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 922.1 сая төгрөгөөр буюу 72.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	56,621.4	39,139.8	(17,481.6)
Авлага	48,704.7	25,668.1	(23,036.6)
Бараа материал	329.9	36,896.2	36,566.3
Үндсэн хөрөнгө	238,772.8	1,163,956.4	925,183.6
Биет бус хөрөнгө		937.5	937.5
Нийт хөрөнгө	344,630.4	1,266,598.0	922,169.2
Өр төлбөр	337,846.9	327,033.1	(10,813.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,783.5	939,564.9	932,781.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	344,630.4	1,266,598.0	921,967.6

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 39139.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 17481.6 мянган төгрөгөөр буурсан байна.
- ✓ Авлага 23,036.6 мянган төгрөгөөр буурсан, тайлант онд үүссэн 25,668.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь байгууллага болон хувь хүнтэй холбоотой авлага бөгөөд тайлант онд барагдуулан ажиллах боломжтой авлага байна.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 36,566.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан бараа материалын үлдэгдэл өссөн нь нөлөөлсөн байна.
- ✓ Үндсэн хөрөнгө өмнөх оноос 925,183.6 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн дагуу хүлээн авсан зоорьтой холбоотой байна.
- ✓ Өглөг данс өмнөх оноос 10,813.8 мянган төгрөгөөр буурсан, тайлант онд 327,033.1 мянган төгрөгийн өр барагдаагүйтэй холбоотой байна.
- ✓ Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч данс нь хуримтлагдсан элэгдлийн зардал нөлөөлжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор үйл ажиллагааны орлогын доод, зарлагын дээд хязгаар, ашиг хуваарилах, орон тоо, цалингийн санг ТУЗ-ийн саналыг үндэслэн аймгийн Засаг дарга хянаж баталгаажуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталаагүй байна.

Тайлант онд тухайн байгууллагын арилжааны банкны дансаар Хөшөөт хөгжил сангаас санхүүгийн дэмжлэг 106.2 сая төгрөг, түрээсийн орлого 10.0 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 22.5 сая, ХОИС-с 17.2 сая бусад эх үүсвэрээс 56.8 сая төгрөг нийт 195.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, 215.5 сая төгрөгийн зардал санхүүжүүлэн ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ -ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор У.Батчимэг 2022 оны 03 дугаар сарын 20-нээс 03 дугаар сарын 25-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нарантуул, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 04/13 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 188.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 158 мэдээллээс 151 мэдээллийг хугацаандаа оруулсан 7 мэдээллийг хугацаа хоцроосон бусад мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин :

Зорилтот түвшний төлөвлөгөө ТУЗ-өөр батлуулаагүй, авлага өмнөх оноос 23.1 сая төгрөгөөр буурсан, өглөг өмнөх оноос 10.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Компани ТУЗ нь эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөний гол үзүүлэлтүүдийн хүрсэн түвшнийг бууруулахгүй байх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй байна.

2. Орлоготой холбоотой асуудал :

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2"Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ" - гэсэн заалтыг зөрчин Хөшөөт хөгжлийн санаас 106.2 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 13.6- д. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэнтэй нийцэхгүй байна.

3. Газар болон ХААДС-ийн зээлтэй холбоотой асуудал:

Ховд агро парк ХХК-ын газар тариалангийн үйл ажиллагаа явуулж буй газар нь 2016 оны 04 дүгээр сарын А/29 дугаар захирамжаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр захирамж гарч тухайн захирамжийг 2018 оны 09 дүгээр сарын 21 ны өдрийн А/106 тоот захирамжаар хүчингүй болгосон байхад тухайн газрын гэрчилгээгээр ХААДС-с барьцаалбар үүсгэн 935.9 сая төгрөгийн үнэ бүхий усалгааны системийн тоног төхөөрөмжийг урьдчилгаа төлбөргүй жилийн 6 хувийн хүүтэй гэрээ байгуулан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д төсвийн захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", гэсэнтэй нийцэхгүй байна.

4.5 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд түүвэрт хамрагдан аймгийн тайланд хяналтыг хэрэгжүүлж тусгайлсан зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлага, өглөг барагдуулан ажилласан эсэх, ИТХ-ын тогтоолоор байгуулж буй аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт орон нутгаас санхүүжилт олгож байгаа асуудлыг аймгийн хэмжээнд хянах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1029.0 сая төгрөгийн алдаа¹ илэрсэн тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд илүү илэрхийлэгдсэн 36.8 сая төгрөгийг илүү бүртгэсэн.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан өвсний орлого 24.3 сая төгрөгийг орлого үр дүнгийн тайланд
- Үндсэн хөрөнгийг Эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн

Аудитаар нийт 499.0 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 493.1 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

5.1. Төлбөрийн акт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- АЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин Хөдөө аж ахуйг дэмжих сангаас хөнгөлөлттэй үнээр Үр үрлэгч, хүнсний нухагч, хүлэмж, зөөврийн усан сан, цаг уурын бичил станц, зэрэг бараа материалуудад шинээр үнэ тогтоон иргэн аж ахуй нэгжид хууль зөрчин 11 хүлэмжийг 5.9 сая төгрөгөөр илүү зарсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

5.2.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой

- Байгууллагын мөнгөн хөрөнгөнөөс тендерийн урьдчилгаа, үр тариа бэлтгэх зардал, тээврийн хөлс, зэрэг зардалд 30-60 хоногийн хугацаатай 31.5 сая төгрөгийн байгууллагын данснаас гарган зарцуулж буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2. батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах заалтуудыг хэрэгжүүлээгүй тул Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төсвийн үргүй зардал гаргаж зориулалт бусаар зарцуулахыг таслан зогсоох албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

5.3.1 Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпорацн ААТҮГ нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 326951.3 мянган төгрөгийн өр, байгууллага болон хувь хүнтэй холбоотой 25.6 сая төгрөгийн авлага үүсгэн ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4. Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах зарчмыг баримтлан авлага, өр төлбөрийг барагдуулж ажиллах.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд илүү илэрхийлэгдсэн 36.8 сая төгрөгийг залруулан бүртгэсэн.	1	36,854.00					1	36,854.00				
Үнэ төлбөргүй хүлээн авсан өвсний орлого 24.3 сая төгрөг бүртгэсэн	1	24,336.00					1	24,336.00				
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг Эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн	1	967,819.33					1	967,819.33				
Дүн	3	1,029,009.33					1	1,029,009.33				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХААДС-аас ирсэн хөнгөлөлттэй бараа материалыг үнэ нэмэгдүүлэн зарсан	1	5.9	1	5.9								
Дансны үлдэгдэл зээл хэлбэрээр гаргасан	1	31.5			1	31.5						
Өр төлбөр, авлага үүсэггүй ажиллах	1	351.9					1	351.9				
Дүн	3	389.3	1	5.9	1	31.50	1	351.9				

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЯДБААТАР

АХЛАХ АУДИТОР:

Д.НАРАНТУУЛ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

У.БАТЧИМЭГ